



БОЛОРЖОНШ ХХК



**ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН
“2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:2830701 /

2023 он

Агуулга

1	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	1
1.1.1	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:	1
1.1.2	Төслийн нэр	1
1.1.3	Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг:	1
1.1.4	Захирлын нэр, утас:	1
1.1.5	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:	1
1.1.6	Тусгай зөвшөөрлийн төрөл	1
1.1.7	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	1
1.2	Төслийн ерөнхий мэдээлэл	1
1.3	Төсөл хэрэгжих талбайн байршил	2
1.4	Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	3
1.4.1	Үйлдвэрлэлийн хүчин чадал	3
1.5	Дэд бүтэц	3
1.5.1	Харилцаа холбоо	3
1.5.2	Зам тээвэр	3
1.5.3	Ус хангамж	4
1.5.4	Цахилгаан хангамж	5
1.5.5	Дулаан хангамж	5
1.6	Хаягдлын аж ахуй	5
1.7	Баяжуулах үйлдвэрийн технологийн процессод ашигладаг химийн бодисууд, жилийн хэрэглээ	6
2	Төслийн талбай, түүний Байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт	7
2.1	Уур амьсгал	7
2.2	Газрын гадрага	7
2.3	Геологийн тогтоц	8
2.4	Хөрсөн бүрхэвч	9
2.5	Гадаргын ус	9
2.6	Газрын доорх ус	10
2.7	Ургамлан нөмрөг	10
3	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	
	11	
3.1	Төслийн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	12
4	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.1	Агаар орчныг хамгаалах төлөвлөгөө	15

4.2	Усан орчин хамгаалах арга хэмжээ.....	17
4.3	Хөрсний эвдрэл, бохирдол, хамгаалах төлөвлөгөө	20
4.4	Ургамлан нөмрөг хамгаалах төлөвлөгөө	22
4.5	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	23
4.5.1	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	23
4.6	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
1.1.1	Дүйцүүлэн хамгаалах газрын байршил.....	25
4.6.1	Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ	28
4.7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	28
4.8	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	28
4.9	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	30
4.10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	31
4.11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	33
4.11.1	Байгаль орчны мониторингийн цэгүүд	33
4.12	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв.....	37
4.13	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	37

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. Төсөл хэрэгжих талбайн захын цэгүүд солбилцол.....	2
Хүснэгт 1-2 Худгийн байршил болон ундрага.....	4
Хүснэгт 1-3. Нийт усны хэрэглээ.....	4
Хүснэгт 1-4. Баяжуулах үйлдвэрийн хаягдлын хэмжээ.....	5
Хүснэгт 1-5 Химийн бодисын агуулахад нөөцлөгдөх хэмжээг хүснэгтээр үзүүлэв.	6
Хүснэгт 1-6 Баяжуулах үйлдвэрт хэрэглэх урвалжийн хэмжээ	6
Хүснэгт 3-1. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	12
Хүснэгт 4-1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	16
Хүснэгт 4-2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ	18
Хүснэгт 4-3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	21
Хүснэгт 4-4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ.....	22
Хүснэгт 4-5. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	23
Хүснэгт 4-6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт 5-7. Дүйцүүлэн хамгаалах талбайн байршил.....	26
Хүснэгт 5-8. Дүйцүүлэн хамгаалах талбай.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 5-9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	28
Хүснэгт 4-8. Баяжуулах үйлдвэрийн технологийн процессод ашигладаг химийн бодисууд, жилийн хэрэглээ	29
Хүснэгт 4-9. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 4-10. Хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөлөл бууруулах арга	30
Хүснэгт 4-11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	32
Хүснэгт 4-12 Орчны хяналт, шинжилгээ хийх байршлууд	33

Хүснэгт 4-13. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ 34

1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр

“Болор Жонш” ХХК

Регистрийн дугаар: 2830701

Улсын бүртгэлийн дугаар: 811002022

1.1.1 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:

Уул уурхай

1.1.2 Төслийн нэр

“ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” төсөл

1.1.3 Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг:

Дундговь аймгийн Баянжаргалан сум, Баянхошуу, Сумын төвд-00

1.1.4 Захирлын нэр, утас:

Захирал: Ц Батсуурь утас 99041322

1.1.5 Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:

Байгаль орчны мэргэжилтэн А.Салтанат утас 99415161

1.1.6 Тусгай зөвшөөрлийн төрөл

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн а/53 захирамжыг үндэслэн Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2-р баг Энгэр ус -1 хаягт байрлах 4802000428 нэгж талбарын дугаар бүхий 150,000 м.кв буюу 15.0 га газар ашиглах 000000302 тоот гэрчилгээг 2019 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр Болор жонш ХХК-д Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн зориулалтаар 5 жилийн хугацаатай олгосон байна.

1.1.7 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд

2021 оны 4 сард Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын яам

1.2 Төслийн ерөнхий мэдээлэл

Хайлуур жоншны хүдрийг олборлож байгаа районд хувийн аж ахуйн нэгж, хувиараа жонш олборлогчид үйл ажиллагаа явуулдаг. Хувиараа жонш олборлогчид болон компани нь олборлолтын ажиллагааг ухагч механизмаар явуулж хайлуур жоншийг сорчлон авч агуулга багатай хэсгийг орхин, хөрс хуулалтыг дутуу хийх, ашигт малтмалын хаягдал, бохирдлыг хяналтгүй болгож ордыг ихээхэн сэглэж сүйтгэн, илрэл бүхий газруудыг гараар ухаж өнгөөр ялган шууд машинд ачаалж олборлолт явуулж түүхийгээр нь экспортлох явдал элбэг байна. Тиймээс энэ баялгийг түүхийгээр хямд экспортлох биш чанарыг нь сайжруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох нь зайлшгүй шаардлагатай байгаа билээ.

“Зүүн-Аргатай” ордыг түшиглэн байгуулах жонш баяжуулах үйлдвэр нь Баянжаргалан сумын 2-р багийн Энгэр-Ус нэртэй газарт байгуулагдах бөгөөд жилд 100.0 мян.т хүдэр боловсруулах хүчин чадалтай, хагас автоматчилагдсан тоног төхөөрөмжтэй, технологийн процессийн хяналтын систем, шинжилгээний лабораторитой үйлдвэр байх болно.


1.3 Төсөл хэрэгжих талбайн байршил

Дундговь аймгийн Баянжаргалан сум нь Улаанбаатар хотоос 300 км, Чойроос 80 гаруй км зайтай оршино. “Болор жонш” ХХК-ийн Баяжуулах үйлдвэрийн талбай нь Баянжаргалан сумын төвөөс 2 км зайтай, талбайн хэмжээ 15 га байна. Судалгааны талбай нь Баянжаргалан сумын төвөөс зүүн урагшаа 2.8 км-т 2-р багийн нутаг Энгэр-ус гэдэг газар байршина

Хүснэгт 1-1. Төсөл хэрэгжих талбайн захын цэгүүд солбилцол

№	Уртраг	Өргөрөг	Х	У	Хэмжээ, м	Талбайн хэмжээ
1	E 108 ⁰⁰ 1/25.59//	N 45 ⁰⁴⁴ /04.44//	268250.05	5069325.04	299.92	15 га
2	E 108 ⁰⁰ 1/15.69//	N 45 ⁰⁴⁴ /19.08//	268525.73	5069443.34	499.87	
3	E 108 ⁰⁰ 1/28.23//	N 45 ⁰⁴⁴ /23.24//	268722.92	5068983.87	299.94	
4	E 108 ⁰⁰ 1/38.13//	N 45 ⁰⁴⁴ /08.61//	268447.21	5068885.57	499.86	

Зураг 1-1. Төслийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн байршил (M1:100000 байрзүйн зураг дээр , L-48-96)



1.4 Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал

“Зүүн-Аргатай” ордыг түшиглэн байгуулах жонш баяжуулах үйлдвэр нь Баянжаргалан сумын 2-р багийн Энгэр-Ус нэртэй газарт байгуулагдах бөгөөд жилд 100.0 мян.т хүдэр боловсруулах хүчин чадалтай, хагас автоматчилагдсан тоног төхөөрөмжтэй, технологийн процессийн хяналтын систем, шинжилгээний лабораторитой үйлдвэр байх болно.

1.4.1 Үйлдвэрлэлийн хүчин чадал

ЖБҮ нь жил бүрийн хаврын 1/IV- ээс өвөл 1/XI хүртэл хуанлийн өдрийн тоо 213 хоног, нийт 176 хоног өдөрт 3 ээлж 8 цагаар 100 т/цагийн хүчин чадалтайгаар ажиллана. Үүнд:

- урсгал засвар, баяр ёслол 9 хоног,
- долоо хоногт 6 хоног ажиллана гэж тооцвол амралтын 28 хоног

Жилд ажиллах хоног 176-180

Баяжуулах үйлдвэрийн нөөц: жилд 100,000.0 т/жил
хоногт 370 - 400 т
цагт 15.4-16.6 т болно.

Үйлдвэрийн ашиглалтын коэффициент, 94.7%.

Хүдрийг баяжуулалтанд бэлтгэх:

- 2 шатны бутлалт
- 1 шатны нунтаглалт
- 1 шатны ангилалт.

Хөвүүлэн баяжуулах процесс (Флотаци):

- 1 шатны үндсэн флотаци
- 1 шатны хяналтын флотаци
- 7 шатны цэвэрлэгээний флотациас бүрдэнэ.

ЖБҮ нь: ▪ Урвалж бэлдэх хэсэг

- Баяжмал шүүн хатаах хэсэг
- Хаягдал хадгалах байгууламжтай байна.

1.5 Дэд бүтэц

1.5.1 Харилцаа холбоо

Баяжуулах үйлдвэрийн ойролцоох төв суурин газрууд нь харилцаа холбоо өндөр хөгжсөн бүсэд хамаарагдана. Үйлдвэр дээр үүрэн телефоны үндэсний байгууллага болох Мобиком, Жимобайл, Юнител зэрэг сүлжээ ажилладаг.

1.5.2 Зам тээвэр

Баяжуулах үйлдвэр нь Дундговь аймгийн Баянжаргалан сумаас 2 км зайд байрлах ба Хөөтийн нүүрсний уурхайн сайжруулсан шороон автозамаас 1.5 км зайд байрлана. Баяжуулах үйлдвэрээс 65 км зайд төмөр замын ачиж буулгах талбай байрлаж байгаа ба баяжуулах үйлдвэрээс гарах жоншны баяжмалыг төмөр замын ачиж буулгах талбай хүртэл авто тээврээр тээвэрлэх ба ачиж буулгах талбайгаас төмөр замын тээврээр тээвэрлэнэ.



1.5.3 Ус хангамж

Технологийн болон ахуйн хэрэгцээний усыг үйлдвэрийн ойролцоо Энгэр усны хөндий байх 2-н өрөмдмөл гүний худаг, баяжуулах үйлдвэрийн хашаанд байх нэмэгдэл нөөц бүхий гүний 1ш 30 кВ-ын насос бүхий өрөмдмөл гүний худгаас хангаж байна. Баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэх усны 70%-ийг эргэлтээр авч ашиглаж байна. Энэ нь хоногт 1361.1 м³ ус байнгын эргэлтэнд байна гэсэн үг юм. Энгэр усны хөндийд гаргасан гүний худгийн ундарга 12.0 л/с байна.

Хүснэгт 1-2 Худгийн байршил болон ундрага.

№	Байршил		Ундарга, л/с	насос
1	108 ⁰ 01'41,88"	45 ⁰ 44'20,12"	2.0	ЭЦВ-6-6.5-120
2	108 ⁰ 01'32,05"	45 ⁰ 44'15,20"	2.5	ЭЦВ-6-6.5-120
3	108 ⁰ 01'26,56"	45 ⁰ 44'15,43"	7.5	ЭЦВ-6-6.5-120

Баяжуулах үйлдвэрийн нийт усны хэрэглээ

Баяжуулах үйлдвэрийн унд ахуй болон үйлдвэрийн усны хэрэглээх дараах хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 1-3. Нийт усны хэрэглээ

№	Хэрэглэгч	Хэрэглээ м ³		
		Хоног	Сар	Жил
1	Баяжуулах үйлдвэр	583.3	17,500	105,000
2	Унд ахуйн хэрэглээ	7.8	234.0	1,404.0
3	Ногоон байгууламж	5.8	174.0	870.0
4	Авто замын усалгаа	6.74	202.0	1,820.0
	Нийт усны хэрэглээ	603.64	18,110.0	109,094.0

Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ: Байгаль орчны сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалаар баталсан “Ашигт малтмал олборлох баяжуулах, боловсруулахад хэрэглэгдэх усны норм”-ын дагуу үйлдвэрлэлийн хэрэгцээнд тооцоход:

100,000 тн х3.5 м³ /тн= 350,000 м³ – баяжуулахад шаардагдах нийт усны хэмжээ. (70%-ийг буюу 245,000 м³ эргэлтээр, 30% буюу **105,000 м³** усны нөхөн сэлбэлтээр хангана). Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны 70%-ийг эргэлтээр авч ашиглах замаар үйлдвэрийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэхээр байна. Ахуйн ус болон үйлдвэрийн ус хангамжинд нийтдээ 3 гүний өрөмдмөл худаг ашиглаж байна. Одоо ашиглаж буй худгийн ундарга нь 12.0 л/с байна.

Унд, ахуйн усны хэрэглээ: Төсөл хэрэгжих хугацаанд хоногт 50-52 хүн ажиллана. Жилийн 180 хоног тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэж үзээд ажиллагсдын хоногийн ба сар, жилийн усны хэрэглээг тооцов. Төслийн унд ахуйн усны хэрэглээг БОАЖ-ын сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалын дагуу тооцсон болно.

1.5.4 Цахилгаан хангамж

Гадаад цахилгаан хангамж

Энгэр-Усны жонш баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг Баянжаргалан сумаас татсан 3 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар цахилгаан эрчим хүчээр хангахаар тусгав.“Болоржонш” ХХК -ийн баяжуулах үйлдвэрийн цогцолборыг Баянжаргалан сум хүртэл татагдсан 35кВ -ийн ЦДАШ -аас 3 км 35кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам татаж, цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийн нийт суурилагдсан хүчин чадал 1389.5 кВт, бүрэн чадал 1422.9 кВт байна.

1.5.5 Дулаан хангамж

Баяжуулах үйлдвэр нь 4 сарын 1-ээс 11 сарын 1-ийг хүртэл жилийн 7 сарын хугацаанд ажиллана. Хүйтний 4 сарын хугацаанд уурхайн олборлолт, ЖБҮ-ийн хүдэр боловсруулалтын ажлыг түр зогсоож ажиллагсадыг амраана. Тус дүүрэгт хавар, намрын улиралд агаарын дундаж температур +10°C ~ -20°C, өвөл нь хуурай, хүйтэн нь -15°C -ээс -25°C хүрдэг бөгөөд хавар намрын улиралд ил уурхай болон баяжуулах үйлдвэрийн барилга багууламжуудыг нам даралтын зуухаар халаахаар төсөлд тусгав.


1.6 Хаягдлын аж ахуй

Хаягдлын сангийн түвшин дээшлэх тусам гадаргуугийн ууршилт ихсэх учир ашиглалтын явцад усан толиог бага байлгахаар тооцож хаягдал болон усны хэмжилтийг тогтмол хийж, ус-шлагын балансын тооцоог нарийвчлан гаргаж ажиллана.

Баяжуулах үйлдвэрийн зутан байдалтай хаягдал нь өтгөрүүлэгчээр орж 35% -иас 55-60% орчим хатуулагтай болон тэндээсээ өндөр нягтралтай полиэтилен (HDPE) яндан хоолойгоор дамжин хаягдлын санд очих ба тэнд хатуу хэсэг нь ёроолд тунаж тунгаасан ус нь эргэлтийн ус болон насосоор үйлдвэрийн тусгай саванд шахагдан очно. Нийт хаягдлын хэмжээг тооцон хүснэгт -д харуулав.

Хүснэгт 1-4. Баяжуулах үйлдвэрийн хаягдлын хэмжээ

Үзүүлэлт		Хэмжих нэгж	Хаягдлын хэмжээ	
			жилд	нийт
Анхдагч хүдэр	Хэмжээ	-	100,000	2,400,000
	Гарц	%	75.62	75.62
Хаягдал	Хэмжээ	т	302480	1814878
Булингын хэмжээ		м ³	338595.8	2031575.0



1.7 Баяжуулах үйлдвэрийн технологийн процессод ашигладаг химийн бодисууд, жилийн хэрэглээ

Үйлдвэрийн флотацийн технологийн процессод 5 нэрийн химийн бодис бүтээгдэхүүн ашиглагдахаар байна. Эдгээр бодисууд нь Монгол улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан хорт болон аюултай бодисын жагсаалтад ороогүй, хүний эрүүл мэндэд хортой эсвэл онцгой хортой ангилалд хамаарах бодих байхгүй. Химийн бодисын агуулахад үйлдвэрийн 20 хоногийн хэрэглээнээс доошгүй хэмжээний нөөцтэй байна.

Хүснэгт 1-5 Химийн бодисын агуулахад нөөцлөгдөх хэмжээг хүснэгтээр үзүүлэв.

№	Бодис, бүтээгдэхүүний нэр, химийн томъёо	CAS дугаар	Зориулалт	Хэрэглээ, жил/тн
1	Натрийн силикат/Шингэн шил (Na_2SiO_3)	6834-92-0	Дарагч урвалж	1020
2	Тосны хүчил ($\text{C}_{18}\text{H}_{34}\text{O}_2$)	112-80-01	Цуглуулагч урвалж	645
3	Цардуул - $[\text{C}_6\text{H}_{10}\text{O}_5]_n$	9004-53-9	Идэвхжүүлэгч урвалж	750
4	Натрийн карбонат/Техникийн сод (Na_2CO_3)	497-19-8	Тохируулагч урвалж	360
5	Полиакриламид- $[\text{C}_3\text{H}_5\text{NO}]_n$	9003-05-8	Тунадасжуулагч урвалж	60

Хүснэгт 1-6 Баяжуулах үйлдвэрт хэрэглэх урвалжийн хэмжээ

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023-р жил
Баяжуулах хүдрийн хэмжээ	мян.тн	100.0
Тосны хүчил	тн	160
Техникийн сод	тн	100
Шингэн шил	тн	14
Натрийн силикат	тн	160
Натрийн фосфат	тн	140
Хөнгөн цагааны сульфат	тн	200
Хувиргасан цардуул	тн	200
Хүхрийн хүчил	тн	20

Эдгээр бодис бүтээгдэхүүнүүдийн физик химийн шинж чанарыг үнэлэхэд шатамхай шинж чанартай 1, идэмхий 2 бүтээгдэхүүн байв. Технологийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөлд үнэлгээнд хамрагдсан бодис бүтээгдэхүүний ашиглалтаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үүсэх эрсдэл бага 3, эрсдэлгүй 2 бүтээгдэхүүн байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх замаар тохиолдож болзошгүй осол аюулын эрсдлийг бууруулах бүрэн боломжтой

2 ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Уур амьсгал


Тухайн нутаг орны уур амьсгалын нөхцөлийг бүрдүүлэх хүчин зүйлийн дотор газрын гадаргын байдал чухал байр эзэлдэг. Дундговь аймгийн Баянжаргалан сумын хувьд хотгор, гүдгэрийн ялгаа төдийлөн их биш учраас уур амьсгалын нөхцөл онцгой ялгардаггүй. Гэвч хөрс, ургамалан бүрхэвчийн байдлаас шалтгаалж, зарим нэг онцлог байдал ажиглагддаг. Их говийн нөлөөтэй бөгөөд мөн бичил уур амьсгалын өвөрмөц нөхцөл зарим газарт илэрдэг онцлогтой.

Жилийн дундаж агаарын температурын 3.5°C дулаан байна. Сарын дундаж температур нь XI-III сард хүйтэн, IV-X сард дулаан утгатай буюу жилийн таван сард нь хүйтэн, долоон сард нь дулаан температуртай байна. Жилд нутгийн баруун хойт хэсгээр 124-172 мм, дунд хэсгээр 60-99 мм, зүүн хэсгээр 33-60 мм хур тунадас орох бөгөөд түүний дийлэх хэсэг нь буюу 80-90% нь дулааны улиралд, бусад нь хүйтний улиралд ордог байна. Дундговь аймгийн нутаг бүхэлдээ салхи ихтэй нутагт хамрагдах бөгөөд жилийн салхины дундаж хурд нь 3.9-5.6м/с-ийн хооронд хэлбэлзэнэ. Салхины хурд нь тухайн орон нутгийн хотгор, гүдгэрийн байдлаас ихээхэн шалтгаалдаг.

2.2 Газрын гадрага

Тухайн газар нь газрын мужлалаар 2-р бүсэд хамаарна. Газрын гадаргын хувьд бэсрэг уулс, хотгор хотос, тойром, цав толгод бүхий ухаа гүвээ ээлжлэн солиглох бөгөөд төслийн талбайн баруун болон зүүн талд нам уул, цав толгод хосолсон гадарга зонхилно. Төслийн талбайд геоморфологийн үндсэн 2 хэв шинжийг ангилах боломжтой. Нам уулс, жижиг толгод, тэдгээрийн ухаа гүвээ давах хэсгийг элэгдлийн гадаргуу, удам тал хөндий, татмын дээрх дэнж рельефийн огцом өөрчлөлтгүй тэгү тал хэсгийг зөөгдөл хуримтлалын гадаргуу гэж үзнэ.

Зураг 2-1. Баянжаргалан сум орчмын геоморфологийн зураглал



2.3 Геологийн тогтоц

Тухайн районы 60%-ийг ангилагддаг хурдас эзэлдэг бөгөөд түүнээс “Болор жонш” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайн орчинд хожуу протерозойн үлдэгдэл, перм, цэрдийн настай хурдсууд, дөрөвдөгч-орчин үеийн сэвсгэр хурдас гүний чулуулагтай харьцан тогтдог байна. Хожуу протерозойн хурдас нь тус районы хэмжээнд нэлэнхүйдээ тэмдэглэгддэг боловч, интузив чулуулаг дотор янз бүрийн хэмжээтэй үлдэгдэл (ксенолит) хэлбэрээр хагарал суулт даган байрладаг ажээ. Ксенолитын хэмжээ нь 1000 м x 500 м-ээс томгүй ба зарим үед 1-5 м орчим цуварсан үлдэгдлүүдээр гадаргууд цайвар зурвас үүсгэн хагарал даган байрлах нь ажиглагдана. Чухам ийм зэргэлдээ 2 зурвас тусгай зөвшөөрлийн талбайн зүүн талаас өргөргийн дагуу 3-4 км орчим үргэлжилж байдаг.


2.4 Хөрсөн бүрхэвч

Судалгааны талбайн Монгол орны физик газарзүйн мужлалаар хээрийн бүсийн гандуу хээрийн дэд бүсэд хамаарах бөгөөд хөрс-газарзүйн мужлалтаар цайвар хүрэн хөрстэй Мандалговийн тойрогт багтана. Эндэхийн ургамалшил тачир сийрэг зарим газраа ургамалгүй цулгуй учраас салхины үйлчлэлд хялбар өртөж, хөрсний өнгөн хэсэг салхинд хийсч эвдрэх үйл явц элсэн хөрстэй газраар байнга ажиглагдана. Нам уулын орой, хяраар хадархаг, хөрсний гадарга дээр нимгэн элс, хөдөлгөөнтэй сайргархаг сайр чулуу ихтэй, чулуу нь том хэмжээтэй, хөрс их хуурайшилттай, хөрсний үе давхарга ямар нэгэн хэмжээгээр сайр чулуу агуулсан байна.

2.5 Гадаргын ус

Баяжуулах үйлдвэр барихаар төлөвлөж буй газар нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах бөгөөд энэ хэсэгт гадаргын усны Төв азийн гадагш урсацгүй мужид багтана. Тус сум нь бүхэлдээ усан сүлжээний хувьд гадаргын урсац саринах бүсэд оршдог. Энэ утгаараа тус ай савд багтах гол горхи хэмжээгээрээ бага, усны горимын хувьд тогтворгүй ихэнхдээ хатаж ширгэдэг байна. Төсөл хэрэгжих талбайн ойр ойрчимд гадаргын ус байхгүй. Хамгийн ойр орших гадаргын ус нь төслийн талбайн зүүн зүгт 20 км зайд түр зуурын хур борооны үед бий болдог нуур байна

Зураг 2-2. Төслийн талбайд ойр орших гадаргын усны зураг



2.6 Газрын доорх ус

Тус районы гидрогеологийн онцлог нь тогтмол урсгалтай гол мөрөн байхгүй. Харин жижиг булгаас эх авсан Талх, Элгэн, Гашуун хар, Баруун аргатай, Алганшанд, Хужирт зэрэг нарийхан горхиудтай боловч, тэдгээр нь судалгааны талбай, түүний ойролцоо байхгүй. Горхины усны урсац бага, урт нь 100-300 метрээс хэтрэхгүй. Зуны сүүлч, намрын улиралд хааяа тохиолдох үргэлжилсэн бороо хурын дараа ихэнх хөндийнүүдэд үер буун их хэмжээний хэмхдэс материал зөөгдөн ирж хуримтлагддаг. Ус нь булингартай, хужирлаг ундны усанд тохирдоггүй. Тэдгээрээс зөвхөн Алагшанд болон Баруун Аргатайн шандын усыг нутгийн иргэд унд-ахуйн зориулалтаар ашиглаж ирсэн байна.

2.7 Ургамлан нөмрөг

Дундговь аймгийн Баянжаргалан сум нь Монгол орны физик газар зүйн мужлалаар Төв халхын тал хээрийн их мужийн хэсэгт байрлана. *Тус Баяжуулах үйлдвэр барих талбай төслийн талбайн ургамалжилт нь бүс нутаг нь тал хээр болон говийн экосистемийн багтаасан өвөрмөц онцлогтой нутаг юм.* Дундговь аймгийн Баянжаргалан сум нь Улаанбаатар хотоос 300 км, Чойроос 80 гаруй км зайтай оршино. “Болор жонш” ХХК-ийн Баяжуулах үйлдвэрийн талбай нь Баянжаргалан сумын төвөөс 2 км зайтай, талбайн хэмжээ 15 га байна. Баяжуулах үйлдвэр орчмын, түүний орчимд гадаргын ил задгай усгүй, судалгааны нэгдүгээр цэг (E 108⁰01'48.2⁰''; N 45⁰44'24.1⁰''; h=1201 м)-ийн орчим дахь ургамалжилтын хувьд авч үзвэл үетэн-алаг өвст, үетэн-алаг өвс-харганат, үетэн-харганат, таана-баглуурт бүлгэмдэл зонхилох ба хазаар өвс, говийн хялгана, агь, гичгэнэ, таана, хөмөөл, бударгана, баглуур, лууль, шаралж, улалж, наптуул зэрэг ургамал зонхилон ургана. Ургамлын тусгаг бүрхэц 70%, үүнд ашигт ургамал 5%, бэлчээрийн ургамал 80%, хүмүүнсэг ургамал 15%-ийг тус тус эзэлнэ. Хаврын хээрийн судалгаагаар авсан дээжинд хагд, борог өвс 30%-ийг эзэлж байна. Жилийн дундаж ургац 1.7 ц/га, байгалийн бэлчээр нутаг юм.

3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвгэрт орших “Жонш баяжуулах үйлдвэр” төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийлээ.

Магадлан жагсаах аргаар үнэлсэн дүнгээс авч үзэхэд байгаль орчинд 45 ширхэг сөрөг нөлөөлөл үүсэхээр байна. Үүнийг байгалийн бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл хөрсөн бүрхэвчинд 18.9%, агаарын чанарт 11.5%, газрын хэвлийд 13.6%, ургамлан нөмрөгт 13.6%, усан орчинд 10.1%, амьтаны аймагт 16.9%, нийгмийн нөлөөлөл 7.2%, тусгай хамгаалалттай газар нутагт 8.2% гэсэн сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Нийт сөрөг нөлөөллийн 18% их, 57% нь дунд, 25% нь бага эрчимтэй байна. Нөлөөллийн үргэлжлэх хугацааны 33% нь түр зуурын, 67% нь богино хугацааных байна. Гол сөрөг нөлөөлөл нь тус үйлдвэрийн үйл ажиллагааны явцад бутлуурын үйл ажиллагаа, хаягдлын сан, хүдэр ачиж буулгах үйл ажиллагаа зэрэг ажлаас үүдэн хүчтэй салхи шуургатай үед агаарт дэгдэх тоосжилтын хэмжээ агаарын чанарын стандартад заасан хүлцэх дээд хэмжээнээс давж гарч болзошгүй. Иймд бууруулах арга хэмжээнд оруулсан бууруулах арга хэмжээг авсанаар сөрөг нөлөөллөөс зайлсхийх багасгах боломжтой

Төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа хийсэн мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь газрын гадарга, агаар, хөрс, ургамал, газрын гүний ус, амьтан юм.

Баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн хэрэгжилтийн байдал болон орчны байдалтай танилцаж холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

3.1 Төслийн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Энгэр ус багийн нутагт хэрэгжиж буй жонш баяжуулах төслийн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, эдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг магадлан жагсаах аргыг ашиглан тодруулж дараах хүснэгтээр үзүүлэв. Магадлан жагсаах арга нь нөлөөлөл байна, байхгүй гэсэн зарчим дээр тулгуурладаг бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэнэ.

Хүснэгт 3-1. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Хэлбэр			хугацаа		давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт											
1	Газрын доорхи урсацын өөрчлөлт		x			x		x		x	
2	Ойн нөөц										
3	Хөрсний эвдрэл, элэгдэл	x				x		x			x
4	Геологийн тогтоц		x			x		x		x	
5	Уур амьсгал	x				x	x			x	
2. Байгалийн нөөц, ашиглалт											
6	Гадаргын нөөц баялаг	x				x		x		x	
7	Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x			x
8	Эрчим хүчний нөөц		x			x		x		x	
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
9	Усны чанар, хэмжээ /ундны ус/	x			x		x		x		
10	Урсгал усны хэрэгцээ										
11	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x		x			x	x		
12	Агаарын бохирдол	x				x	x				x
13	Хөрсний бохирдол	x			x			x		x	
14	Дуу чимээний нөлөө	x				x		x		x	
4. Нийгэмд үзүүлэх нөлөө											
15	Ус хэрэглээний асуудлаар бусад байгууллагатай зөрчилдөх										
16	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x				x		x	x		
17	Нүүлгэн шилжүүлэх асуудал гарах										
18	Хүн амын орлого өөрчлөгдөх	x				x		x	x		
19	Хүн амын тоо өөрчлөгдөх										
5. Байгалийн өнгө төрх											
20	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x	x		
21	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
22	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
23	амрах нөхцөлд нөлөөлөх										
6. Түүхийн дурсгалт зүйл, соёлын өв, археологи палентологийн олдвор											
24	Түүхийн нөлөөлөх дурсгалт зүйлд										
25	Археологи олдворт нөлөөлөх, палентологийн										
7. Эдийн засаг, нийгэм											

“Болор жонш” ХХК-ий жонш баяжуулах үйлдвэрийн төслийн 2023 онд хийгдэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Хэлбэр			хугацаа		давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
26	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x		x	
27	Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		x	
28	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх										
29	Ажлын байр нэмэгдэх	x				x		x	x		
30	Ядуурлыг бууруулах дэмжлэг болох	x			x			x	x		
Дүн		16	4		6	16	5	17	10	9	3

Шууд нөлөөлөл: Болзошгүй нөлөөллийн 16 нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд газрын гүний нөөц баялаг болох хайлуур жоншийг ашиглах нь байгалийн нөөцийг хомсдуулах, жоншийг бутлах, шигших, үед үүсэх тоос, нарийн ширхэгтэй шороо, тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос, хүнд даацын машин, механизмын дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас үүсэх утаа болон хорт хий болон тоног төхөөрөмж, хүнд даацын машинаас гарах дуу чимээнээс шалтгаалж ойр орчмын агаар бохирдохоос гадна хөрсний бохирдол үүсэх үндсэн шалтгаан болж байна. Харин тухайн үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулснаар ажлын байр, орон нутгийн болон хувийн өмчийн орлого нэмэгдэх зэрэг эерэг сайн нөлөөтэй юм.

Шууд бус нөлөөлөл: Хаягдлын даланд аюултай осол гарах, газрын доорх усыг хүдэр баяжуулалт, зам талбайн усалгааны зориулалтаар авч ашиглахад түүний нөөцөд өөрчлөлт гарах, их хэмжээний овоолго үүссэнээс газрын тогтцыг нь өөрчлөхөд хүргэх зэрэг нөлөөлөл энд хамаарч байна.

Буцаж нөлөөлөх нөлөөлөл: Энэ нөлөөлөлд хог хаягдлыг замбараагүй хаях, ариутгал хийхгүй байх нь хөрс ургамлаар дамжин усанд нөлөөлөл магадлалтай. Энэ нь буцаж хүн амын эрүүл мэндэд эргэж муугаар нөлөөлнө. Мөн машин, техникийн хөдөлгөөн ихэссэнээс хөрс эвдрэлд орох улмаар ургамлан бүрхэвчийн бүтэц өөрчлөгдөж лууль, шарилж хөл газрын ургамал ургах боломж бүрдэнэ. Энэ нь хүний эрүүл мэндэд буцаж сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Урт хугацааны нөлөөлөл: Тус үйлдвэр нь цаашид үйл ажиллагаагаа урт хугацаанд тогтвортой явуулах тул дээр дурьдагдсан шууд ба шууд бус нөлөөллүүд бүгд урт хугацааны нөлөөлөлд хамаарна.

Нөлөөллийн эрчим: Болзошгүй нөлөөллийн ихэнх нь дунд ба бага зэргийн эрчимтэй нөлөөлөлд хамаарч байгаа хэдий ч техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанарын өндөр түвшинд хийх зайлшгүй шаардлагатай.

Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх тоос ба хорт хий, (CO₂, SO₂, NO, NO₂, CO) зэрэг нь агаарын

чанарт тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлнэ. Иймд цаашид агаарын бохирдлыг бууруулахын тулд үйлдвэрийн ил талбайн замыг хатуу хучилттай болгох, үйлдвэрлэлийн бус талбайг зүлэгжүүлэн ногоон байгууламжтай болох, мод бут тарих зэргээр тохижилтын ажлуудыг хийх нь зүйтэй. Мөн үйлдвэрээс босоо тэнхлэгийн гол автозам хүртэлх 1.3 км замыг орон нутаг, төсөл хэрэгжүүлэгч нартай хамтран хатуу хучилттай болгоход анхаарч ажиллах нь зүйтэй.

Тус үйлдвэр нь өндөр хүчдэлээр ажилладаг үндсэн тоног төхөөрөмжүүдтэй тул цахилгааны болон галын аюулаас хамгаалах талаар онцгой анхаарч болзошгүй осол аваарын үед шуурхай хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах, авран хамгаалах шуурхай групп зохион байгуулах, гал түймэр унтраах багаж хэрэгсэл, ажиллагааны найдварт нөхцөлөөр хангасан байхаар бэлэн байдалд байлгах шаардлагатай. Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн ба санхүүгийн боломж, шуурхай хяналтын асуудлуудын талаар болон ажиллагсдыг мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн үеийн хөдөлмөрийн чадвар түр алдалт гаргахгүй байх талаар жил бүрийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөнд тодорхой тусгаж түүнийгээ нарийн мөрдөж ажиллах хэрэгтэй.

.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 2023-2024 оны хугацаанд хэрэгжих бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх үндэслэл болно.

“БОЛОР ЖОНШ” ХХК-ий захиргаа нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн жилийн үйл ажиллагааныхаа зардалд тусган төлөвлөж, зарцуулалтанд хяналт тавих үүрэгтэй.

4 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Агаар орчныг хамгаалах төлөвлөгөө

Хүдэр ачих, буулгах ажлын үед:

- Хүдэр ачих, буулгах үед ажлын талбай орчимд их хэмжээний тоос үүсэхээс гадна агаар орчинг бохирдуулдаг. Иймд зам талбайг услах, тоос дарах арга хэмжээнүүдийг авах.
- Зам талбайг байнга тэгшилж, бульдозер болон автогрейдерээр сул шороог хусч зайлуулах
- Хүчтэй салхи шуургатай үед газар шорооны ажлыг хязгаарлах, хийхгүй байх
- Эвдрэлд орсон газрын боломжтой хэсгийг нь тухай бүрт нь үржил шимт хөрсөөр бүрхэж ургамалжуулах.

Тээвэрлэлтийн үед:

- Хүдэр, хөрс болон баяжмал тээвэрлэх үед тухайн орчинд маш их тоос тархах тул автозамыг услах, сул шороо, чулууг хусч зайлуулах, зам хатууруулагч тусгай зориулалтын бодис ашиглах,
- Тоос шороог багасгахад услах болон тоос дарах зориулалтын уусмалыг ашиглах,
- Тээвэрлэлтийн замын сүлжээг сайтар төлөвлөх, зөвхөн батлагдсан замын сүлжээг ашиглах, олон салаа зам гаргахгүй байх, замын тэмдэглэгээ хийх, сайжруулах,
- Үйлдвэрт ажиллах тоног төхөөрөмжүүдийн хөдөлгүүрээс гарах хорт хийг хүлцэх хэмжээнд байлгахад техникийн бүрэн бүтэн байдал чухал байдаг. Иймд техник, тоног төхөөрөмжийг тогтмол үзлэг оношлогоонд оруулах, засвар үйлчилгээг байнга хийж хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлэх,

Нөлөөллийн товч тодорхойлолт: Салхи шуурга ихтэй үед ордын ашиглалтын талбайгаас тоос босч орчны агаарт бохирдол үүсгэнэ. Хөрсний чийг бага, салхины хурд их байх үед агаар дахь тоосны хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх үндэслэлтэй.

Нөлөөлөлд өртөх объект:

Ажиллагсдын түр оршин суух байр сууц, ордын талбайн орчимд байгаа хүн, мал, компанийн ажиллагсад нөлөөлөлд өртөнө

Хүснэгт 4-1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /төгрөг /	Баримтлах стандарт, аргачлал
Хүдэр ачиж буулгахад болон хийх хүнд даацын машин зэргийн нөлөөллөөр их хэмжээний сул шороо дэгдэж агаарт байх нарийн ширхэгтэй тоосонцорын агууламж нэмэгдэх	Хүдэр ачиж, тээвэрлэх шороо тоос босгохгүйн тулд замын гадаргуу, хүдэр овоолох талбайг графикийн дагуу байнга чийгшүүлж байх	Үйлдвэрийн хашаан дотор	Ажил гүйцэтгэж дуусах хүртэл дотоод зардал	Агаарын тухай хууль MNS 4585:2007, MNS 4601:2011
	Агаарын чанарын дээжлэлт графикийн дагуу байнга явуулах хийх		450,000	
	Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах болон салхинаас хамгаалах зорилгоор мод бут тарих	Төслийн талбай	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан зардал	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага
	Агаарын чанарын иж бүрэн багаж суурилуулах			Агаарын тухай хууль MNS 4585:2007, MNS 4601:2011
Тээвэрлэлттэй холбоотой тоос, шороо босох	Төслийг хэрэгжүүлэх үед дотоод болон гадаад зам, барилгын ажлын туслах үйл ажиллагааны талбайг тоос бага босох материалаар хучих Зам, талбайг усалж, чийглэх Тогтоосон замаас еер газраар машин техник зам гаргахаас сэргийлж хаалт, хамгаалалт хийх.	Үйлдвэр хүрэх 650 м шороон зам барилга байгууламж баригдах дотоод зам талбай	450,000	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль (2012.05.17) MNS 0017-2-3-16:1998 (суурьшлын хэсгүүдэд) MNS 4585:2007 Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага
Жонш баяжуулах үйлдвэрт ажиллах хүнд даацын тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн яндангаас барилгын ажлын хугацаанд нийт үүсэх хорт хий агаарт цацагдаж, орчны агаарын чанар, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх ба ойр орчмын хөрс, ургамлыг бохирдуулна.	Түлшээр ажилладаг тоног төхөөрөмжүүдээс ялгарах утааны хэмжээг хянаж, яндангийн шүүр зэргийг тогтмол шалгаж, эвдэрсэн эд ангийг шинэчилж байх Машин, механизм, тоног төхөөрөмжийн дотоод шаталтат хөдөлгүүрт сайн чанарын түлш, шатахуун хэрэглэх	Төслийн талбай болон төсөл хүрэх 650 метр авто зам	300,000	Агаар мандал. Бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлох MNS 3383:1982, Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2007, MNS5885:2008 Агаарын бохирдлыг үүсгэгч бодисын агууламж. Техникийн ерөнхий шаардлага
	Үйлдвэрийн материал түүхий эдийг эмх цэгцтэй хурааж байрлуулах	Үйлдвэрийн хашаа	Дотоод зохион байгуулалтаар	
Нийт дүн			1,200,000	

4.2 Усан орчин хамгаалах арга хэмжээ

Нөлөөллийн товч тодорхойлолт: Тус унд ахуй болон технологийн хэрэглээний усыг Баяжуулах үйлдвэрт гаргасан 3 худгаас ашиглана.

Нөлөөлөлд өртөх объект: Гүний ус /хөрсний ус/

Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Үйлдвэрийн хэрэглээний усны буцаан авах, дахин ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх, усыг дахин хэрэглэх, эргэлтэнд оруулах, урсгал сөргөн буцаан ашиглах зэргээр усны хэрэглээг хэмнэх арга хэмжээг авах шаардлагатай.
- Ахуйн хэрэгцээнээс гарах хаягдал усыг цэвэршүүлэн MNS 4943 : 2011 “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага” стандартын түвшин хүртэл цэвэршүүлэн зам талбайн тоосжилтыг дарахад эргүүлэн ашиглах
- Хэрэглээний усны салаалсан хоолойнуудад усны тоолуур суурилуулж, усны хэрэглээг хэмжиж, хянаж, үргүй зардлыг багасгах
- Үйл ажиллагааны түвшинг дээшлүүлж, үр дүнтэй удирдлагын аргачлал болоод стандартыг боловсруулан, зураг төслийн шаардлагын дагуу усны хэрэглээнд хяналт тавьж, төсөвлөсөн зарцуулалтын хэмжээнд барих зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
- Ус дамжуулах шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг хангаж байнгын хяналт тавих
- Бохир ус цэвэршүүлэлтийн технологид хяналт тавьж стандарт, нормын хэмжээнд хүрч ажиллах
- Ашиглаж байгаа усны жилийн хэмжээг багасгахын тулд орчин үеийн дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, ус эргүүлэн ашиглах системийн ашигт үйлийн коэффициентийг нэмэгдүүлэх
- Гадаргын болон хөрсний уснаас үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглох
- Гүний усны нөөц, чанарт байнгын хяналт тавьж, үйлдвэрлэлийн хэрэгцээнд зарцуулагдаж байгаа усны хэмжээг гүний усны нөөцийн 3/1-ээс хэтрүүлэн ашиглахыг хатуу хориглох зэрэг арга хэмжээг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай

Хүснэгт 4-2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал /төгрөг/	Баримтлах стандарт, аргачлал
Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ				
Үйлдвэрийн ажлын талбайд барилгын материалын хуримтлал, хураалт, барилгын болон ахуйн хог хаягдал бороо цасны усаар угаагдаж зөөгдөн хөрсний капилляр нүх сүвээр дамжин гадаргын болон газрын усны чанар, найрлагад нөлөөлөх.	Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно. Үйлдвэрийн ажлын талбай, ажлын байранд янз бүрийн материал эдлэхүүн, тоног төхөөрөмжийг холбогдох норм дүрэм, стандартад заасны дагуу хадгалж, байрлуулах;	Үйлдвэрийн нийт талбайд	400,000	Үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм-Ерөнхий шаардлага” /БНБД-12-03-04/-ын 6.3.3 Усны тухай хууль 22.1 MNS 4047 : 1988 MNS 4586-1998. MNS 3342-1982
Шатах тослох материал, шатахууны алдагдал, хөрсөөр нэвчин гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.	Гүний ус, байгаль орчинг бохирдуулахгүй байх анхааруулга, санамж бүхий самбар хийх	Машины зогсоол, машин тэрэг зорчих хэсэг	350,000	Байгаль хамгаалах хууль, Усны тухай хууль.
Усны замбараагүй, тооцоогүй хэрэглээнээс газрын доорх усны түвшин буурах.	Үйлдвэрийн ажилд шаардлагатай цэвэр усыг зөвшөөрөлтэй худаг, уст цэгүүдээс авч ашиглах, зөвшөөрөлгүй худаг гаргаж ус худаг гаргах, суваг шуудуу татахыг хориглоно	Төслийн гүний худаг дээр	Төслийн өдөр тутмын үйл ажиллагааны зардал	MNS 0899:1992 Унд, ахуйн зориулалттай эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага MNS 0900:2010 Ундны усны чанарын стандарт - Байгаль орчныг хамгаалах хууль 31.3 Усны тухай хууль 24.4
	Усны зарцуулалтын мэдээ тайлан гаргаж, зохистой зарцуулалтыг хянах.		Усны тоолуурын заалтаар тооцож төлөх	
	Ус ашигласны төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах,		Дотоод зардал	
	Ус ашиглуулах дүгнэлтийг сав газраас авах		Дотоод зардал	
	Газрын доорх усны нөөцийг үйлдвэрийн ажил эхлэхээс өмнө 2023 онд холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах			
	Ус ашиглах эрхийг БОАЖЯ-аас авах			
Нөхөн сэргээлт болон ногоон байгууламж арчлахад саарал ус ашиглах	Бохир ус цэвэршүүлэх байгууламж	Дотоод зардал	MNS BS 8525-1-2015. Саарал усны систем. Ерөнхий шаардлага MNS 4943:2011.	
Бохирын цооног дүүрч халих, цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн доголдол	Цохир усны цооногийн доторлогоо, тохижуулалтыг хийж гадаргын урсац зайлуулах суваг татсан байна	байгууламжийн инженер шугам хоолой хийсэн		MNS 3342:1982 Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.

“Болор жонш” ХХК-ий жонш баяжуулах үйлдвэрийн төслийн 2023 онд хийгдэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал /төгрөг/	Баримтлах стандарт, аргачлал
хариуцлагагүй байдлын улмаас ахуйн бохир ус хөрсөнд шингэх замаар бохирдол тархаж гадаргын болон газрын доорх усыг бохирдуулах	Доторлож тохижуулсан цооногийг ашиглалтад оруулах зөвшөөрлийг байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагаас авах	газар болон ариун цэврийн газарт	350,000	MNS 6148:2010 Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-01-14;
Төслийн талбайд үүсэн хог хаягдал уруйн болон хур борооны үерийн усаар зөөгдөн гадаргийн ус бохирдуулж болзошгүй	Төслийн талбайд үерийн далан шуудууг стандартын дагуу зөв байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах	Төслийн талбай, түүний эргэн тойрны үерийн далан	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд	Гамшгаас хамгаалах тухай хууль,
	Үерийн далан шуудуунд бөөгнөрсөн хогийг тогтмол цэвэрлэж байх		Ажилчдаар хийлгэх тул цалингийн сангаар	
	Бохир ус цуглуулах цементэлсэн доторлогоотой септик танк кемп бүр дээр байгуулж, саармагжуулж ногоон байгууламжинд ашиглах.			
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал			1,100,000	

4.3 Хөрсний эвдрэл, бохирдол, хамгаалах төлөвлөгөө

Нөлөөллийн товч тодорхойлолт: Ордын ашиглалтын үйл ажиллагааны улмаас хөрсний бүтэц өөрчлөгдөж, үржил шим бууран хөрс эвдрэлд орох, хатуу шингэн хог хаягдлаар хөрс бохирдох нөхцөл бүрдэнэ.

Нөлөөлөлд өртөх объект:

Баяжуулах үйлдвэрийн талбайн хөрс бүхэлдээ шууд нөлөөлөлд өртөнө.

Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Баяжуулах үйлдвэрээс гарсан хаягдал чулуулгийг байгалийн нөлөөгөөр эвдэрсэн, гуу жалгатай газрыг сонгон орчны гадаргуутай ландшафтын хэлбэршлийн хувьд нэгдмэл бүтэц бий болгоход анхаарах
- Овоолгыг тойруулан үер, уснаас хамгаалах далан шуудуу байгуулах
- Тээвэрлэлтийн явцад машин, техникийн даацыг хэтрүүлэхгүй байх.
- Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрч доройтсонгазрууд болон хаягдал овоолгын огцом налуу хажууг сайтар хэлбэршүүлэн засч техникийн нөхөн сэргээлтийг чанартай хийсний дараа шимт хөрсөөр хучна. Үүний дараа биологийн нөхөн сэргээлтийн ажлаар олон наст өвслөг болон буурцагт ургамал тариалж талбайг хөрсжүүлж, ургамлан нөмрөгтэй болгох ажлууд хийх
- Олон салаа зам гаргахгүй байхаас гадна ашиглалтанд өртөхгүй талбайг эвдрэлд оруулахгүй байхад анхаарах
- Тээвэрлэлтийн замыг эмх цэгцтэй зохион байгуулж тогтсон маршрутаар явах.
- Шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүнээр хөрсийг бохирдуулахгүй байх, сэргийлэх үүднээс ШТМ-ын хадгалалт, түгээлтэд онцгой анхаарч, түүнийг асгарч, алдагдахаас урьдчилан сэргийлэх
- Хөрсөнд шатах, тослох материал болон бусад бодис асгарч алдагдсан тохиолдолд нэн даруй цэвэрлэх арга хэмжээг авах, шаардлагатай техник хэрэгсэлээр хангах.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
- Хөрсийг ахуйн хог хаягдал, химийн бодис, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх арга хэмжээг авна.
- Хаягдлын сангын далангийн тогтвортой байдалд байнгын хяналт тавих.
- ОХШХ-т заасан хугацаанд хөрсний шинжилгээг хийлгэж шинжилгээний үр дүнд үндэслэн хөрсний үржил шимийг хадгалах арга хэмжээгээ төлөвлөж хэрэгжүүлэх.
- Хөрсний хяналтын цэг дээр хяналт шинжилгээг тогтмол хийх.
- Хөрсөнд хор нөлөө үзүүлэхгүй био ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлэх.
- Уурхайгаас боловсруулах үйлдвэр хүртэл нийт 1.3 км орон нутгийн замыг сайжруулж хайрган хатуу хучилттай болгох.

Хүснэгт 4-3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал /төгрөг	Баримтлах стандарт, аргачлал
Үйлдвэрийн дотор хүдэр буулгах, ачих талбайн газрын гадарга техноген нөлөөнд өртөх.	Ногоон байгууламж байгуулах /эдэлбэр газрын 20%-иас доошгүй талбайд/	Үйлдвэрийн талбайд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан зардал	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага
	Тээвэрт ашиглах хүнд даацын машин техникийн дотоод болон гадаад замыг тогтоосон маршрутаар явуулах. Салаа зам гаргахаас сэргийлж тэмдэг тэмдэглэгээ нэмж байршуулах	Үйлдвэрийн хашаанд	200,000	
Хүний буруутай үйл ажиллагаа болон байгалийн гамшигаас үүдэлтэй хаягдалын сан задрах гэмтэх, хөрсөн бүрхэвч бохирдох	Үйлдвэрийн ойр орчим болон хаягдлын сангийн ойр орчимд байнгын хяналтын цэг байгуулж, бохирдсон хөрсөн бүрхэвч бүхий хэсгийг саармагжуулах цэвэрлэх.	Үйлдвэрийн талбайд, хаягдлын сан	550,000	-
Шатах тослох материал, техник хэрэгслийн эд ангиар хөрс бохирдох	Шатах тослох материал асгаруулж болохгүй хөрс, ургамал зэргийг хамгаалах сурталчилгааны самбарууд байгуулах, ШТМ-аар бохирдсон хөрсийг тээвэрлэн цуглуулах талбайд тээвэрлэн хүргэж саармагжуулах	Машины зогсоол, машин тэрэг зорчих хэсэг	400,000	MNS 3297:1991 MNS 3985:1987 MNS 5850:2006 MNS 5342-2007.
	Авто зогсоол болон бусад газар автомашинаас шатахуун болон бусад тос тослох материалын асгаралт үүсэж хөрсөнд нэвчихээс сэргийлж байнгын хяналт тавих,		Төслийн менежерийн ажил үүргийн хуваарьт оруулан цалингийн зардалд орно	
Ахуйн хог хаягдлыг хөрсөнд шууд хаяснаар хөрс бохирдох	Хатуу хог хаягдал хадгалах түр цэгийг байгуулах, хогийн цэгийн талбайг нэмэгдүүлэхгүй байх	Төслийн талбай	300,000	Хог хаягдлын тухай хууль 10.2.11,10.3.6, 10.3.2, 10.3.5, 10.3.3, 10.2.1-10.2.4 MNS 5344:2011
	Хог хаягдлыг тогтмол хугацаанд хогийн цэгт зайлуулах сумтай хамтран ажиллах		Хог хаягдлын менежментийн зардлаар	
	Барилгын ажлын үед энгийн нүхэн жорлон ашиглахгүй ба байгальд ээлтэй технологи бүхий био жорлонтой байна.	Ажилчдын түр суурин	дотоод зардал	MNS 5924: 2015. MNS4943:2015
Бохирын цооног дүүрч халих, соруулж зайлуулах үед, гэмтэл саатлын улмаас шингэн хаягдал алдагдаж хөрсөнд химийн болон биологийн бохирдол үүсэх	Цэвэрлэх байгууламжийг үйл ажиллагаа, хүчин чадалдаа тохируулан сонголт хийж, ахуйн бохир усыг хоолойгоор зайлуулж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар захын объектээс 20 метр, булгийн эргээс хамгийн багадаа 30 метр зайтай газар суурилуулах	Төлөвлөсөн талбайд	Тухайн үед зардал тусгах	MNS 4943:2000 Байгаль орчны сайд, эрүүл мэндийн сайдын 1995 оны 169/171 тоот тушаалаар батлагдсан “Ахуйн бохир ус хаях цооногийг доторлож ашиглах журам”
	Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг үе үе хянах, тухай	Төслийн бохир усны цооног,	Тухайн үед зардал тусгах	

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал /төгрөг	Баримтлах стандарт, аргачлал
	бүр нэн даруй мэргэжлийн байгууллагаар засвар хийлгэх	гадна шугам хоолой		
Нийт дүн			1,450,000	

4.4 Ургамлан нөмрөг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөллийн товч тодорхойлолт

Газар шорооны ажил болон машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан нөмрөгт нөлөөлөл үзүүлнэ.

Нөлөөлөлд өртөх объект

Ордын талбай, түүний ойр орчны ургамлан бүрхэвч

Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга

Хүснэгт 4-4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал /Мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг	Хяналт тавих байгууллага
1.	Төсөл хэрэгжих үеийн машин техникийн зам, салаа зам гаргахаас урдчилан сэргийлж, тэмдэг тэмдэглээ, маршрут гаргах	2023 онд	Агаар орчин хамгаалах арга хэмжээнд тусгасан	Замын тэмдэг тэмдэглээ	Байгаль орчны ажилтан Болоржонш ХХК
2.	Орд ашиглалтын үед ургамлын бүрхүүл бүхий эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлт хийх	2023 онд	0.9 га /зардлыг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан/	Биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал	Байгаль орчны ажилтан, Болоржонш ХХК
	Дүн		0.00		

4.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Болоржонш” ХХК-ий “Энгэр усны жонш баяжуулах үйлдвэрийн ойр орчим барилгын ажил болон ашиглалтын ажлаар эвдрэлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх юм.

Төслийн үйл ажиллагаагаар эвдэрсэн талбайг хөдөө аж ахуйн бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгнө. Нөхөн сэргээлтийн ажлын зардлуудыг “Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2015 оны 03 сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалын хавсралт болох нөхөн сэргээлт хийгдэх ажлын үнэлгээ тооцох ргачлалын дагуу тооцсон. Далангийн гадаргуугийн талбай 162526 м² буюу 16.3 га талбайг хамарч байна.

Хүснэгт 4-5. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ

№	Төслийн нэр	Талбайн хэмжээ	Эвдрэлт өртөх талбай / га /
1	Баяжуулах үйлдвэр	Баяжуулах үйлдвэрийн талбай, Бутлуур, Пүү, авто зам гэх мэт	2.7 га
2	Кемп	0.3 га хүртлэх талбайг эзлэнэ.	0.3 га
3	Овоолго	Тухайн үеийн нийлүүлэгчээс шалтгаалж овоолго хийх бөгөөд 30-40 мян.м3 хүдрийн овоолго нөөцөнд байна.	1 га
5	Ил уурхай → баяжуулах үйлдвэр	Баяжуулахын эзэмшил замын урт нь 1.8 км.	1,26 га
6	Хаягдлын сан	Хаягдлын сан байгуулах тусгай зөвшөөрөлт талбайн хэмжээ	15 гектар
	Нийт дүн		20.26га

4.5.1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Болоржонш” ХХК-ийн “Жонш баяжуулах үйлдвэрийн Хашаан дотор ногоон байгууламж бий болгох: Мөн сумаас үйлдвэр хүрэх авто замын дагуу мод тарих ажлыг төлөвлөв. Үйлдвэрийн барилгажаагүй 10800 м² сул талбайг ургамалжуулах ажлын нийт зардал нь **3,748.56** мян.төг болж байна

Хүснэгт 4-6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Биологийн нөхөн сэргээлт						
Үйлдвэрийн ажлын нөлөөгөөр талхагдсан газрыг нөхөн сэргээх	Үйлдвэрийн талбайн талхлагдсан хэмжээнээс хамаараад 5-10 м радиус орших газарт биологийн нөхөн сэргээлт хийх. Ургамалжуулахдаа үржил шимт хөрсөөр 0.3 м зузаантай хучилт хийж олон наст ургамал тарьж, хөрсийг ширэгжүүлнэ. Мөн талхлагдсан газрыг хөрсийг сэргээж олон наст ургамал тарина	Төслийн барилга байгууламж барих ажлын үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын биологийн нөхөн сэргээлтийг 1.2 га талбайд хийх ба таримал олон наст үетэн болон хос үрийн талт ургамлын үр нийт 500 кг шаардлагатай.	-	3,748,560	2023онд	”Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” /MNS 5918-2008/; БОНХАЖ сайдын тушаал А-138 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал.
Үйлдвэрийн замын дагуу мод сөөг, тарир.цэцэрлэг жүүлэх	Ногоон байгууламжийг хур бороо орсны дараа байшин барилга, явган зорчигчийн хучаастай замаас аль болохоор их усыг ногоон байгууламжинд саадгүй урсан оруулахаар бодож зам талбайг барьж байгуулах, усалгааны системийг бий болгох, Ямар ч ургамалд газрын дээд хэсэгтэй тэнцүү хэмжээний үндэсний систем байдаг тул ургамал тарих зайг тохируулах	Нийт замын дагуу буюу 1.3 км замд улиас, улиангар, шар хуайс нийт 500 ширхэг мод тарина. 1.8 биологийн нөхөн сэргээлт хийх	5	2,500,000	2023онд	
Нөхөн сэргээлтийн арга хэмжээний зардал				6,248,560		

4.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн нөлөөлөлд өртсөн газрын хэмжээг тогтоосны дараагаар төслийн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоодог. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооход дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ. Амьдрах орчны төрөл; Экосистемийн ховор байдал; Экологийн эрүүл байдал; Ландшафтын байршил; Нөлөөллийн хугацаа.

“Болоржонш” ХХК-ийн хувьд 2021 онд **Аймаг, сумын ЗДТГ, тэдгээрийн асуудал хариуцсан байгууллага, орон нутгийн оролцогч талууд, төсөл хэрэгжүүлэгч зэрэг талуудтай** зөвшилцсөны дараа дүйцүүлэн хамгаалахаар сонгогдсон газарт газар төлөвлөлт, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ, биотехникийн арга хэмжээний судалгаа зэрэг ажлууд нэмэлтээр хийгдэхээр байгаа. Кобид-19 цар тахлын улмаас 2020-2022 оны хооронд үйл ажиллагаа явуулахгүй зогссон.


Энэ жил дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээнд Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийнэ. “Болоржонш” ХХК-ий Баяжуулах үйлдвэр болон “Зүүн Аргатай”-н хайлуур жоншны уурхайн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хамтад нь авч үзэх бөгөөд зохих дүрэм журмын дагуу судлан ажиллах болно. **2023 оны хувьд дүйцүүлэн хамгаалах газрын сонгож тухайн газрын өнөөгийн байгаль орчны төлөв байдлын судалгаа хийнэ.**

1.1.1 Дүйцүүлэн хамгаалах газрын байршил

Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоохдоо нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, экологийн хувьд дүйцэхүйц байх зарчмыг баримтална. Тухайлбал:

- Нөлөөлөлд өртсөн биологийн олон янз байдалтай экологийн хувьд дүйцэхүйц байх
- Газарзүйн байршлын хувьд оролцогч талуудын эрх ашгийг хангахуйц байх газрыг сонгох нь зүйтэй. Хэрэв өмнө дурдсан экологийн хувьд дүйцэхүйц байх зарчмыг хангаж болох бол дүйцүүлэн хамгаалах газрыг нөлөөлөлд өртсөн газартай аль болох ойр байхаар тогтооно. Өөрөөр хэлбэл, нэг аймаг, сумын хилийн дотор үзүүлсэн нөлөөллийг хэрэв экологийн хувьд боломжтой бол тухайн аймаг, сумын хилийн дотор байхаар сонгох нь зүйтэй. Мөн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийг баримтална.
- “Болоржонш” ХХК “Зүүн аргатай хайлуур жоншны ордыг ашиглах” төслийн “Дүйцүүлэн хамгаалах талбайн Баянжаргалан сумын Аргатай баг Ястын уурхай газарт Уурхайлалтанд өртөж эзэнгүй үлдсэн талбайг **Аймаг, сумын ЗДТГ, тэдгээрийн асуудал хариуцсан байгууллага, орон нутгийн оролцогч талуудтай зөвшөөлцөний үүдэн нөхөн сэргээхээр болсон.**

Хүснэгт 4-7. Дүйцүүлэн хамгаалах талбайн байршил



4.6.1 Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ

Төслийн нөлөөлөлд өртсөн газрын хэмжээг тогтоосны дараагаар төслийн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоодог. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооход дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ. Амьдрах орчны төрөл; Экосистемийн ховор байдал; Экологийн эрүүл байдал; Ландшафтын байршил; Нөлөөллийн хугацаа.

“Болоржонш” ХХК-ийн хувьд 2020-2024 онд Аймаг, сумын ЗДТГ, тэдгээрийн асуудал хариуцсан байгууллага, орон нутгийн оролцогч талууд, төсөл хэрэгжүүлэгч зэрэг талуудтай зөвшилцсөнөөр тухайн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдэх нөхөн сэргээлтийн зардлыг мэргэжлийн байгууллагатай хийх гэрээний хүрээнд шийдэгдэх болно.

Хүснэгт 4-8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал /төгрөг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг	Хяналт тавих байгууллага
1.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах талбайн байгаль орчны төлөв байдлын судалга хийнэ. Уурхайн карьер овоолгын талбайн хэмжээтэй ижил хэмжээтэй байна.	2023 онд	1,500,000	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	Болоржонш ХХК болон гэрээт байгууллага
Дүн			1,500,000.00		

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Болоржонш” ХХК-ий Хайлууур жоншны баяжуулах үйлдвэр үйл ажиллагааны явцад ямарч нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөхгүй болно.

4.7 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Болоржонш” ХХК-ий “Хайлууур жоншны баяжуулах үйлдвэрийн талбайн районд түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй болно.

4.8 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Жонш баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх явцад химийн хорт болон аюултай бодис ашиглах үйл ажиллагаа явагдах тул химийн бодис ашиглаж үйл ажиллагаа явуулдаг төсөл хэрэгжүүлэгчид эрсдэлийг бууруулах, арилгах арга замыг сайтар судалж мэдсэн байвал зохино. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд тухайн бодисын үйлчлэлтэй холбоотойгоор үүдэн бий болох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх болон эрсдэлийг бууруулах, арга хэмжээ, эрсдэлд нэрвэгдэгсдэд үзүүлэх анхны тусламж зэргийг хамруулан үзсэн болно.

Хүснэгт 4-9. Баяжуулах үйлдвэрийн технологийн процессод ашигладаг химийн бодисууд, жилийн хэрэглээ

№	Бодис, бүтээгдэхүүний нэр, химийн томъёо	CAS дугаар	Зориулалт	Хэрэглээ, жил/тн
1	Натрийн силикат/Шингэн шил (Na ₂ SiO ₃)	6834-92-0	Дарагч урвалж	1020
2	Тосны хүчил (C ₁₈ H ₃₄ O ₂)	112-80-01	Цуглуулагч урвалж	645
3	Цардуул - [C ₆ H ₁₀ O ₅] _n	9004-53-9	Идэвхжүүлэгч урвалж	750
4	Натрийн карбонат/Техникийн сод (Na ₂ CO ₃)	497-19-8	Тохируулагч урвалж	360
5	Полиакриламид- [C ₃ H ₅ NO] _n	9003-05-8	Тунадасжуулагч урвалж	60

Баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулахад үйлдвэрийн 20 хоногийн хэрэглээнээс доошгүй хэмжээний нөөцтэй байна.

Хүснэгт 4-10. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Гарах үр дүн	Нэгжийн өртөг (төгрөг)	Баримтлах эрхзүйн баримт бичиг аргачлал, стандарт
Химийн бодисыг тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах	Химийн бодис асгарсан үед хөрс, усан орчинд бохирдол үүсгэхээс сэргийлнэ	1,200,000	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2-р бүлэг
Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм боловсруулж, мөрдөж ажиллах		Дотоод зардал	
Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслүүдийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байршлыг заасан самбар, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах тослох материалын аюулгүй ажиллагааг хангана	Дотоод зардал	Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга 3-р бүлэг, MN85078-2001
Ажиллагсдын дунд цахилгаан хэрэгсэлтэй харьцах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулах		1,500,000	Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, барилгын салхивч агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага MNS5390:2004 ХААЭА
Шатахууны агуулахын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, хөдөлмөр аюулгүйн ажилтанд хариуцуулах		Дотоод зардал	Цахилгааны, галын аюулгүй байдал : ерөнхий шаардлага
Аянга цахилгааны иж бүрэн газардуулга хийх			
Цахилгааны шитний аюулгүй байдал, газардуулгын акт, баталгаажуулалттай байх	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах тослох материалын аюулгүй ажиллагааг хангана	1,000,000	
Цахилгааны аюулгүйн дохиолол ажиллуулах, аюулгүйн салгууртай байх		Дотоод зардал	
Машин механизм, тоног төхөөрөмжийг зураг төслийн дагуу угсарч суурилуулсан акттай байх		Дотоод зардал	
Цахилгааны тоног төхөөрөмжийн газардуулгын даацын баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байх		Дотоод зардал	

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Гарах үр дүн	Нэгжийн өртөг (төгрөг)	Баримтлах эрхзүйн баримт бичиг аргачлал, стандарт
Тоног төхөөржмийн засвар үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугцаанд		Дотоод зардал	
Тогтмол хийж, техникийн ашиглалтын паспортод тэмдэглэдэг байх		Дотоод зардал	
Даралтат сав, шугам хоолойд дохиолол хамгаалалтын систем ажиллуулдаг байх, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны заавартай байх		Дотоод зардал	
Хаягдлын сангийн тогтворжилтийг тогтмол хянах, шаардлагатай тохиолдолд засах	Хаягдал хадгалах байгууламжийн далан нурах болзошгүй эрсдлээс сэргийлнэ	Ус, усан орчны БОМТ-д тусгасан	
Нийт		3,700,000	

4.9 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Кемпийн ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэрт ажиллагсдын амрах байр, гал зуух, ажлын байр, угаалгын өрөө гэсэн үндсэн объектуудаас гарах хог хаягдлууд ордог болно.

Судалгаанаас үзэхэд уурхайд ажилладаг 1 хүнээс өдөрт дундажаар 1-1,5 кг хог хаягдал үүсдэг байна. Тэгвэл “Баяжуулах үйлдэрийн хувьд өдөрт 50-60 хүн ажиллаж, хоногт үүсэх ахуйн гаралтай хог хаягдлын хэмжээ нь 25-37.5 кг болж байна. Уурхайг зөвхөн дулааны улиралд 180 хоног ажиллуулна гэдгийг тооцвол хатуу хог хаягдлын нийт хэмжээ нь 4.5 тн – 6.75 тн байна. Үүнийг зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаях ба уурхайн захиргаа хариуцан ажиллахаар төлөвлөж байна.

Нөлөөллийн товч тодорхойлолт: Ахуйн хатуу, шингэн хог хаягдал, машин техникийн шатах тослох материалаас орчны хөрс бохирдоно.

Нөлөөлөлд өртөх объект:

Орчны хөрс, ургамлын бүрхэвч, мал амьтан

Хүснэгт 4-11. Хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөлөл бууруулах арга

Эх үүсгэврээс гарах хог хаягдал	Жилд гарах нийт хэмжээ	Хадгалах	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал	Аргачлал, стандарт	
Ахуйн	Ажилчдын шингэн хаягдал бохир ус	486 м.куб	Шингэн хаягдал хадгалах саванд хадгалах ба цаашид цэвэршүүлж дахин ашиглана.	50,000*12= 600,000	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344 : 2011 “Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, цуглуулах,
	Ажилчдын ахуйн хатуу хог хаягдал	8.8тн	Ангилан, ялгаж цуглуулаад хоёрдогч түүхий эд нийлүүлэх цэгт тушаана.	65,000*12= 780,000	
	Техник, тоног төхөрөмжийн эвдэрсэн сольсон эд анги, бусад				

Эх үүсгэврээс гарах хог хаягдал		Жилд гарах нийт хэмжээ	Хадгалах	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал	Аргачлал, стандарт
Аюултай	Автомашины болон тоног төхөөрөмжийн тос, тослох материалын үлдэгдэл, сав баглаа, боодол, түүгээр бохирдсон зүйлс	-	Хоёрдогч түүхий эд нийлүүлэх цэгт тушаана.	-	тээвэрлэх, устгах” журам
Хаягдлын сан	Тоосго, цемент, шороо, мод модон бүтээгдэхүүн, цаас, гялгар уутан сав баглаа боодол, хаягдал төмөр, дулаалгын материал, будаг, шахдаг хөөсний лааз, хуванцар сав, шил, замаск, кабель утас, хар тос, дээврийн материал	Тодорхойгүй	Үйлдвэрийн хаягдлын сан байнгын хяналт тавьж / үнэр гарах, далан сэтэрх, осол аваар гарах / сэргийлэх	500,000	Хог хаягдлын тухай хууль 10.2.11
	Хаягдлын сангийн орчим 3 ширхэг хяналтын цооног ерөмдөж байнгын хяналт хийх		Газрын доорх ус бохирдохоос сэргийлэх. Хаягдлын сангийн хяналт	Дотоод гэрээгээр	
Тухайн жилийн төсөв (мян.төг)				1,880,000	

4.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Болоржонш ХХК-ийн удирдлагын зүгээс Баяжуулах үйлдвэрийг ашиглахдаа удирдлага зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрийн технологийн заавар, горим, стандарт, аюулгүй ажиллагааны шаардлага, заавар дүрмийг ажиллагсдад эзэмшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах.
- Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг бүрэн хангаж Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах үндэсний хөтөлбөр”, “Аж ахуй нэгж байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм”, “Ашигт малтмалын ордыг ил аргаар олборлоход мөрдөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн заалтуудыг мөрдлөг болгон ажиллах.
- “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, эрх зүйн актууд, тогтоол журам шийдвэр, стандарт шаардлага, зөвлөмжийг судлаж баяжуулан мөрдөх.
- Жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг цаг тухайд нь авч хэрэгжүүлэх ажлыг доорхи удирдлага зохион байгуулалтын системийн дагуу биелүүлж ажиллах нь чухал гэж үзлээ

Хүснэгт 4-12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хийгдэх ажил	Хугацаа, давтамж	Зарцуулалтын зардал (мян.төг)	Аргачлал, стандарт
		2023 он	
Байгаль орчны хуваарьт аудит хийлгэх	2 жил тутамд	Гэрээний үнийн дүнгээр	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹
Хог хаягдлыг ангилан ялгах дахин ашиглах талаар ажиллагсад сургалт хийх	Сар тутам	Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын тухай хууль 9.2.2-9.2.9
Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах			
Болзошгүй осол, аюулын үед орон нутгийн эмнэлэгийн болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар гэрээ байгуулах	Гэрээний дагуу	Гэрээний үнийн дүнгээр	Гамшгаас хамгаалах тухай хууль
Ус ашиглах гэрээ, хог хаягдлын гэрээг жил бүр сунгаж ажиллах	Жил тутам	-	Усны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль
БОМТ-г сонирхогч талуудад мэдээлэх	Жил бүрийн 4-р улиралд	-	Байгаль орчны хамгаалах тухай хууль 14.1.2
Байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлын тайланг жил бүр боловсруулан БОАЖЯ-т хүргүүлэн, удирдах дээд байгууллагаар батлуулах	Жил бүрийн 12-р сарын 01-ны дотор	-	“БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3,4-р хавсралтууд
Газрын төлөв байдлын улсын чанарын хянан баталгааг тогтоосон хугацаанд хийлгэх	5 жилд нэг удаа	Гэрээний үнийн дүнгээр	Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 10.1 “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам”
Хог хаягдал, ус, газар ашигласны болон бусад шаардлагатай төлбөрийг хуулийн дагуу дүүргийн захиргаанд төлж байх	Гэрээний дагуу	Гэрээний үнийн дүнгээр	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31,2
Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.	Жил тутам	Тухайн жилийн БОМТ-ний зардлын 50%-тай тэнцэх мөнгөн хөрөнгө	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 9.9
Газрын доорх усны нөөцийг үйлдвэрийн ажил эхлэхээс өмнө 2023 онд холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах	-	2023онд	
Нийт		+	

4.11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

4.11.1 Байгаль орчны мониторингийн цэгүүд

Хайлуур жоншны уурхайн ажлын явагдах газар нутгийн байгаль орчны төлөв байдал, онцлог, нөлөөллийн эх үүсвэрүүдийн байршил, нөлөөллийн эрчим, тархалт зэрэг хүчин зүйлсийг тооцон үзсэний үндсэн дээр дараах цэгүүдийг байгаль орчны мониторингийн цэгүүдээр сонгов. Сонгож авсан эдгээр 5 мониторингийн цэгүүдээс тухайн сард баяжуулахын ажил идэвхтэй явагдаж буй цэгүүдийг нь сонгон авч тухайн сарын мониторинг хэмжилтийг хийнэ. Баяжуулахын ажлын явц, гүйцэтгэл, ажлын хэмжээ, нөлөөлөл зэргээс хамаарч мониторинг хяналт тавих цэгийн тоо сар бүр харилцан адилгүй байх магадлалтай юм.

Орчны хяналт шинжилгээний ажлуудыг үйлдвэрийн ажил явагдах хугацаанд сар тутам буюу жилд 6-аас доошгүй удаа явуулж байх нь зохистой юм.

Хүснэгт 4-13 Орчны хяналт, шинжилгээ хийх байршлууд

№	Мониторингийн цэгийн нэр	Замын тэмдэглэгээ	Мониторингийн чиглэл
Баяжуулах үйлдвэрийн мониторингийн цэг			
1	Хүдэр буулгах талбай	108° 1'26.32"E 45°44'7.80"N	Агаар, хөрс
2	Ажилчдын кемп	108° 1'19.09"E 45°44'16.84"N	Агаар, гадаргын ус, хөрс
3	Хаягдлын сан	108° 1'35.92"E 45°44'10.65"N	Агаар, гадаргын ус, хөрс
4	Авто зогсоол	108° 1'31.22"E 45°44'17.49"N	Агаар, хөрс
5	Үйлдвэрийн орчим	108° 1'25.20"E 45°44'13.82"N	Агаар, хөрс

Зураг 4-1. Орчны хяналт, шинжилгээ мониторингийн цэг



Хүснэгт 4-14. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ	Нэгж өртөг, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал(мян.төг)	Баримтлах стандарт арга, аргачлал,
Агаарын хяналт шинжилгээний хөтөлбөр							
Нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/	Мкг/м	Үйлдвэрийн салхины зонхилох чиглэлийн дагууд (ЗУ,БХ) 100, 200,300, 500 метр зайд	Жилд 2 удаа (өвөл, зун)	7 цэгт тус бүрт 4 удаа ба нийт 20 сорьц	-	Гэрээний үнийн дүнгээр	MNS: 3598-1983.
Азотын давхар исэл /NO2 /							MNS: 17.2.5.11-1988.
Хүхэрлэг хий /SO2 /							MNS: 17.2.5.12-1988.
Хар тугалга /Pb/							MNS: 3384-1982.
Бенз-а-дирен /C ₂₀ H ₁₂ /							
Нийт тоос /TSP/	Мкг/м	Үйлдвэрийн хашаанд зонхилох салхины дагуу 1 цэгт	Жилд 2 удаа 4-10-р саруудад	Сорьцын тоо 1 ширхэг нэг жилд 1 удаа ба нийт	25.0	150.0	MNS: 4048-1988
Агаарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал						150.0	
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөр							
Хөрсний чанарын шинжилгээ. Хөрсний хими-физикийн ерөнхий үзүүлэлтүүд (Механик бүрэлдэхүүн, чулуу, нягт, чийгшил, ялзмагийн агууламж, рн, давсжилт, NO3-N, P 2O2, K2O)	Үзүүлэлт тус бүрийн шинж чанараас хамаарч нэгж өөр өөр байна (% , гр, гр-экв)	Ажилчдын байрын дунд	Жилд 1 удаа	5 цэгт тус бүрт 2 удаа ба нийт 10 дээж	20.0	200.0	MNS: 3298-1991.
		Хатуу хог хаягдлын цэгийн талбайд					
		Бохир ус цэвэршүүлэх байгууламжийн талбайд					
Хөрсний чанар –Хүнд металлууд (Cd, Se, CN, F, As, Co, Cr, Cu, Mo, Ni, Pb, Sn, Sr, V, Zn)	Мг/кг	Авто машины зогсоол орчимд	Жилд 1 удаа	5 цэгт тус бүр 4 удаа ба нийт 20 дээж.	20.0	200.0	
		Хог хаягдал хадгалах түр цэг					
Гэдэсний савханцарын таньц Эмгэг төрөгч нян Энтерококк	Тоо ширхэг	Хог хаягдал хадгалах түр цэг бохир ус цэвэршүүлэх байгууламжийн талбайд	Жилд 1 удаа	5 цэгт тус бүр 1 удаа ба нийт 5 дээж.	9.5	47.5	MNS:3985-87.
					7.5	37.5	
					5.5	27.5	
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал						662.5	
Ундны болон бохир усны хяналт шинжилгээний хөтөлбөр							

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ	Нэгж өртөг, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал(мян.төг)	Баримтлах стандарт арга, аргачлал,	
Усны чанар- (ph,T0, TDS, EC, Ca,Mg, K, Na, F, SO4,Cl, Fe, CO3, HCO3,NO3-N, NO2, NO3, хатуулаг, TSS, Ag, Al, B, Ba, Be,Ca, Cd, Co, Cr, Cu, Mn, Mo, Ni, P, Sb, Se, Sr, Zn, Fe, Fe+2, Fe+3, Pb, Hg, Ti, As)	Мг/л, мг-экв/л, °C, ппм,мксм/См	Ундны усанд хэрэглэж буй шугамнаас	Жилд нэг удаа	1 цэгт 1 удаа нийт 5 дээж	33.0	165.0	MNS ISO: 5667-5-2001. MNS ISO: 5667-11-2001.	
Ундны усны бичил амьсудлалын аюулгүй үзүүлэлт	Тоо ширхэг		Сард нэг удаа	1 цэгт жилд 3 удаа, нийт 5 шинжлүүлэх	50.0	250.0		
Цэвэршүүлсэн усны физик, химийн үзүүлэлт	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч Умбуур бодис Нефть, нефтийн бүтээгдэхүүн Сульфид Хлорид Сульфат Ph Фосфат Нитрит Нитрат Аммиак Шүлтлэг Исэлдэлт Өнгө	Үзүүлэлт тус бүрийн шинж чанараас хамаарч нэгж өөр өөр байна (мгО/л, %, мгN/л,мгP/л, мэдрэхүй, мг/л)	Бохир ус цэвэршүүлэх байгууламжинд орж ирж буй болон цэвэршүүлээд гарч буй усанд	Хагас жилд нэг удаа	1 цэгт тус бүр 2 удаа 5 дээж шинжлүүлэх	8.0	40.0	MNS ISO: 5667-10-2001.
						8.0	40.0	
						5.0	25.0	
						10.0	50.0	
						5.0	25.0	
						15.3	76.5	
						11.5	57.5	
						1.7	8.5	
						5.0	25.0	
						4.5	22.5	
						5.5	27.5	
						3.6	18	
						2.5	12.5	
						4.0	20.0	
2.0	10.0							
Ундны болон бохир усны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал						873.0		
Хаягдлын сангийн орчим 3 ширхэг хяналтын кооног өрөмдөж байнгын хяналт хийх						Гэрээний үнийн дүнгээр		
Ургамалжилтын хяналт шинжилгээний хөтөлбөр								
Ургамлын зүйлийн бүрдэл, хөгжлийн үе шат	Үзүүлэлт тус бүрийн шинж	үйлдвэрийн орчинд Явган хүний зам дагуу	Жилд 1 удаа, ургамлын	2 цэг тус бүрт нэг удаа нийт 5 удаа	50.0	250.0		

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ	Нэгж өртөг, мян\төг	Хэрэгжүүлэх хугацаа ба зардал(мян.төг)	Баримтлах стандарт арга, аргачлал,
буюу фенологи, ургамлын тусгаг бүрхэц, газрын дээрх биомассын дээж, хөрсний чийг, температур, рН, давсжилт, хөрсний тогтвортой байдал	чанараас хамаарч нэгж өөр өөр байна (% , гр, удаа)	Авто зогсоолын ногоон байгууламж	ургалтын хугацаанд	мэргэжлийн зөвлөх ажиллуулж ургамлын бичиглэл хийлгэн үр дүнг боловсруулах			
		Ариун цэврийн газрын орчны талбай					
Ургамалжилтын хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал						250.0	
Орчны физик үзүүлэлтийн хяналт шинжилгээний хөтөлбөр							
Дуу чимээ	Дба	Ажилчдын байр сууц	Жилд нэг удаа	2020-2024 онд нийт 4 удаа	2.6	2.6	MNS 5002:2000, MNS 4996:2000 MNS 4990:2015
Гэрэлтүүлэг	Люкс				3.7	3.7	
Агаарын урсгалын хурд	М/сек				4.2	4.2	
Дуу чимээ /шөнө-өдөр/	Дба				Гадна орчинд	2.6	
Орчны физик үзүүлэлтийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал					-	13.1	
Байгаль орчны хяналт шинжилгээний тухайн жилийн нийт зардал					-	1,948.6	

4.12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулагдах төсвийн нэгдсэн дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

№	Төлөвлөгөө	Төсөв
1.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт	1,948,600 төгрөг
2.	Байгаль хамгаалах төлөвлөгөөнд	3,750,000 төгрөг
3.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд	6,248,560 төгрөг
4.	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	1,500,000 төгрөг
5.	Хог хаягдал арга хэмжээ	1,880,000 төгрөг
6.	Химийн бодисын арга хэмжээ	3,700,000 төгрөг
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв:		19,027,160 төгрөг

4.13 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт болно. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийг доорх хүснэгтэнд үзүүлэв.

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах	Зохион байгуулах газар
Төслийн ойр орчмын иргэд, Баянжаргалан сумын ЭДарга холбогдох мэргэжилтэн	Хэлэлцүүлэг зохион байгуулах, санал авах	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 4-р улиралд	Сумын засаг захиргааны удирдлага болон байгаль орчны байгууллагын санал, шүүмж, хорооны оршин суугчдын санал, гомдолыг хүлээн авч шийдвэрлэх	Баянжаргалан сумын иргэдийн танхимд
Шаардлагатай тохиолдолд байгаль орчны төрийн бус байгууллага		Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Жил бүрийн 4-р улиралд	БОХ арга хэмжээний тайлангийн ирэх оны төлөвлөгөөнд дээр санал авч хамтран ажиллах	

“Болор жонш” ХХК-ий жонш баяжуулах үйлдвэрийн төслийн 2023 онд хийгдэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах	Зохион байгуулах газар
		хийгдэж буй ажил			
Аймгийн БОАЖГ	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хэвлэмэл болон файл хэлбэрээр	БОМТ-ний биелэлт	Жил бүрийн 11-р сарын 01-ны дотор	Хянуулан дүгнэлт гаргуулах	Дундговь аймгийн БОАЖГ
БОАЖ Яам	Дараа жилийн БОМТөлөвлөгөө, тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг тус бүр 3 хувь үйлдэж цахим (баримт бичиг бол *.pdf, зураг бол *.shp форматаар DVD болон SD картад)	БОМТ-ний биелэлт, ирэх оны БОМТөлөвлөгөө	Жил бүрийн 12-р сард багтаан	Хянуулан батлуулах	УБ хот, БОАЖЯ